

Малын бэлчээр ашиглалтыг сайжруулах асуудал

Бадамдоржийн Батхишиг

Академич, доктор (Sc.D), профессор
Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэн
Улаанбаатар, Монгол Улс
batkhisigb@mas.ac.mn

Хураангуй

Бэлчээрийн мал аж ахуй бол түүний үндсэн нөхцөл болох бэлчээр, түүний усжуулалт, мал эмнэлэг, мал зүй гээд олон хүчин зүйлээс бүрэлдэн хамаарах үйлдвэрлэлийн цогц систем юм. Гэхдээ энэхүү өгүүлэлд мал аж ахуйн үйлдвэрлэлийн үндсэн нөхцөл болох бэлчээрийн ашиглалтыг сайжруулах асуудлыг онцлон авч үзэв.

Түлхүүр үгс: *бэлчээрийн даац, бэлчээрийн төлбөр, бэлчээрийн менежмент*

Issues of improving the use of livestock pastures

Batkhisig Badamdorj

Academician, doctor (Sc.D), professor
Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences
batkhisigb@mas.ac.mn

Abstract:

In the article the author considers the issue of pasture overloading as one of the most urgent problems of livestock breeding in Mongolia. The article consists of two parts. In the first part, the author characterizes the current state of pasture use and shows how overloaded pastures are and what are the main causes of pasture overloading and its consequences.


In the second part, the author suggests some ways to reduce the overloading of pastures, such as introducing the law on payment for pasture use, improving pasture management, regulating the number of livestock by increasing domestic consumption and export of meat and others.

Keywords: *pasture overload, payment for the use of pastures, pasture use management*

Нэг. Малын тоо толгойн өсөлт ба бэлчээрийн даацын хэтрэлт

Монгол орон зах зээлийн харилцаанд шилжиж эхэлсэн 1990 оноос хойш мал сүргийн тоо үсрэнгүй өссөн нь шинэ нөхцөл дэх тус салбарын хөгжлийн нэг гол үзүүлэлт юм. Таван хошуу малын тоо 2022 онд 71.1 сая толгойд хүрч, зах зээлийн өмнөх 1990 оныхоос 2.7 дахин өслөө. Зураг 1-ийг үзнэ үү. Өнгөрсөн 30 гаруй жилд хамгийн их тоогоор өссөн нь ямаа байна. Ямааны тоо энэ жилүүдэд 5.4 дахин өсжээ. Хонь 2.1 дахин, адуу 2.2 дахин, үхэр 1.9 дахин өсөж, харин тэмээний тоо 12.5 % -иар багасжээ.

Зураг 1. Малын тооны өсөлт, сая толгойгоор (ҮХС 2017; 2022 , 459; 629)



Мал сүргийн тоо толгой ийнхүү үлэмж өссөнийг юуны өмнө хувийн өмчид шилжсэнтэй холбон тайлбарлаж байна. Гэвч 1959-1990 оны хоорондох 30 гаруй жилээс бусад үед, өөрөөр хэлбэл, үеийн үед Монголын мал сүрэг хувийн өмчид байж ирсэн. Тэгсэн мөртлөө 2010 оныхоос хойших үеийнх шиг ингэж хурдан өсөж, ийм их тоонд хүрч байсангүй. 1921 оноос өмнө буюу феодализмын үед малын үлэмж хэсэг нь феодал ноёд, жас болон том лам нарын өмчид байж, тэдгээрийг хамжлага ардууд болон шавь нар маллаж, адгуулж байв. Харин 1990 онд мал сүрэг хувьчлагдсанаар түүнийг өсгөн үржүүлдэг жинхэнэ эзэддээ очжээ. Тэгэхээр мал сүрэг хурдан өссөний гол шалтгаан нь чухам малыг малчдад өгсөн явдал, өөрөөр хэлбэл, малыг хариулан өсгөдөг жинхэнэ эздэд нь шилжүүлсэн явдал юм. Мал хувийн өмч болсноор малчид мал маллаж өмч хөрөнгөө арвижуулах сонирхолтой болов. Хэрэв 1990 онд малчин өрх 74170, малчид 147508 байсан бол 2021 онд малчин өрх 188605 болж 2.5 дахин, малчид 305430 болж 2.1 дахин нэмэгдсэн байна.

Мал сүрэг өсөхөд нөлөөлсөн өөр нэг хүчин зүйл бол усан хангамж сайжирсан явдал гэж зарим мэргэжилтэн үзэж байна. Сүүлийн үед гүний худаг өрөмдөж, худаг гаргах ажил өргөжсөнөөр бэлчээрийн усан хангамж сайжирч, мал сүрэг өсч үржихэд таатай нөхцөл бүрдүүлсэн байна.

Гадаад худалдаанд уул уурхайн түүхий эд, бүтээгдэхүүн давамгайлах болсон нь малын тоо толгой өсөх чухал нөхцөл болсон билээ. Эрдэнэтийн зэс,

молибдений баяжуулах үйлдвэр баригдахаас өмнө Монголоос гадаадад гаргадаг барааны дийлэнхийг мал болон малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн эзэлж байв. Тавантолгойн нүүрсний уурхай, Оюутолгойн зэсийн орд газрыг эзэмшиж эхэлснээр нүүрсний ба зэсийн баяжмалын экспорт эрс нэмэгдсэн билээ. Үүний зэрэгцээ цайрын хүдэр, баяжмал, гянтболдын хүдэр, баяжмал, хагас боловсруулсан алт, тунгаасан зэс, хайлш, боловсруулаагүй газрын тос зэрэг экспортын шинэ төрлийн бараа бий болжээ. 2000 онд Монголын нийт экспортод эрдэс бүтээгдэхүүн 35.2 хувийг эзэлж байсан бол 2022 онд 84.1 хувийг эзлэх болжээ (ҮСХ 2017; 2022, 414; 498).

Малын тоо ийнхүү өсөж урьд өмнө байгаагүй хэмжээнд хүрсэн нь том ололт амжилт мөн боловч мал аж ахуйн цаашдын хөгжилд анхаарч шийдвэл зохих олон асуудал хуримтлагдсанаас хамгийн ноцтой нь бэлчээрийн даац хэтэрч байгаа явдал юм. Бэлчээрийн аж ахуйн гол онцлог бол малчид зөвхөн мал сүргээ л өмчилж, мал аж ахуйн үйлдвэрлэлийн гол нөхцөл болсон бэлчээрийг өмчлөхгүй, зөвхөн ашиглаж байгаад оршино. Монгол Улсын Үндсэн хуульд “бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно.” (Монгол Улсын Үндсэн хууль 1992) гэж заасан.

Тус улс өндөр уул, хангай, хээр, говь бүс хосолсон 110.3 сая га бэлчээр, 1.7 сая га хадлангийн талбай нийт 112.0 сая га бэлчээр, хадлангийн талбайтай. Энэ нь хөдөө аж ахуйн эдэлбэр газрын 97 хувийг эзэлдэг бөгөөд 52.0 сая га-г өвөл, хаврын улиралд, 60.0 сая га-г зун намрын улиралд тус тус ашиглаж байна. Малчид бэлчээрийг жилийн 4 улирлаар нүүдэллэн хуваарьтай ашиглаж, мал аж ахуйн үйлдвэрлэлийг бэлчээрийн доройтлоос хамгаалж ирсэн уламжлалт аргатай. Гэвч сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт, малын тоо бэлчээрийн даацаас хэтэрсэн, бэлчээрийг сэлгэн ашиглах явдал багассан, бэлчээр дэх хортон, мэргэгчдийн тоо хэт олширсон зэрэг олон шалтгааны улмаас бэлчээр талхлагдаж, ургамлын зүйлийн бүрэлдэхүүн цөөрч, ургац буурч, байгаль экологийн тэнцвэрт байдал алдагдаж эхэлжээ.

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн 2022-2023 оны өвөл, хаврын бэлчээрийн даацыг баг бүрийн бэлчээрийн ургац, малын тоо, бэлчээрийн талбайн хэмжээ, бэлчээр ашиглах хугацаа зэрэг мэдээлэлд үндэслэн тооцоолоход нийт нутгийн 34.4 хувьд бэлчээрийн даац 1-3 дахин хэтэрсэн, 7.7 хувьд 3-5 дахин хэтэрсэн, 18.4 хувьд олон дахин хэтэрсэн гэсэн дүн гарчээ. Өөрөөр хэлбэл, өвөл-хаврын бэлчээрийн даац нийт нутгийн 40 орчим хувьд хүрэлцээтэй, харин 60 гаруй хувьд хэтэрч гарсан байна. Баян-Өлгий, Увс, Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Өмнөговь, Өвөрхангай аймгуудын ихэнх сум, багийн нутгаар даац хэтэрч гарсан байна. Нийтдээ 70 орчим сумдад бэлчээрийн даац олон дахин хэтэрсэн ажээ (www.dnn.mn 2022).

Бэлчээрийн даац хэтрэхэд малын тоо үлэмж өссөн явдал голлон нөлөөлсөн нь тодорхой. Манай улсын эрдэмтэн, мэргэжилтнүүд Монголын бэлчээр нутагт байвал зохимжтой мал сүргийн тоог тооцон гаргасан. Тухайлбал, академич А.Бакей тэргүүтэй эрдэмтэн мэргэжилтнүүд Монголын бэлчээрийн даацын судалгааг хийж дараахь тооцоог гаргажээ.

*Хүснэгт 1. Бэлчээрийн боломжит даацад тохирох малын тоо
(2017-2030 оны төлөв) (Б.Пүрэв, А.Бакей 2020)*

Малын төрөл	Бэлчээрийн боломжит даац /мянган толгой/		А ба В улирлын бэлчээрийн боломжит даацаар тодорхойлогдох малын тооны ялгаа	Мах үйлдвэрлэлийн боломжит хэмжээ, амьдын жингээр, (мянган тонн)	
	Зун, намрын улиралд /А/	Өвөл, хаврын улиралд /В/			
Тэмээ	379.0	266.3	112.7	24.1	
Адуу	3171.3	2228.0	943.3	131.5	
Үхэр	4128.6	2900.6	1228.0	150.7	
Хонь	21203.6	14896.8	6306.7	146.9	
Ямаа	17781.8	12492.9	5288.9	85.7	
Нийт толгой	Биет тоогоор	46664.3	32784.6	13879.6	538.9
	Хонин толгойд шилжүүлснээр	87209.9	61270.4		

Хүснэгт 1-ээс харахад Монголд зун, намрын улиралд хонин сүрэг 21.2 саяас илүүгүй, өвөл, хаврын улиралд 14.9 саяас илүүгүй байх ёстой ажээ. Гэтэл Монгол Улсад 2022 оны эцсийн байдлаар 71.1 сая толгой мал, түүний дотор 32.7 сая хонь байв. Хүснэгт 2-ыг үзнэ үү.


Хүснэгт 2. Бодитой байгаа малын тоо ба бэлчээрийн боломжит даацаас хэтэрсэн тоо (ҮСХ 2022, 614-617)

Малын төрөл		Тоо толгой (мянган толгой)	Зун, намрын улиралд байвал зохих тооноос хэтэрсэн (мянган толгой)	Өвөл, хаврын улиралд байвал зохих тооноос хэтэрсэн (мянган толгой)
Тэмээ		470.5	91.5	204.2
Адуу		4800.0	1628.7	2572.0
Үхэр		5500.0	1371.4	2599.4
Хонь		32700.0	11496.4	17803.2
Ямаа		27600.0	9818.2	15107.1
Нийт тоо	Биет тоогоор	71100.0	24406.2	38285.9
	Хонин толгойд шилжүүлснээр			

Хүснэгт 2-оос харахад бүх төрлийн малын тоо бэлчээрийн даацтай нийцтэй байвал зохих тооноос хамаагүй давжээ. Ялангуяа хонь, ямааны тоо 9.8-11.8 саяар илүү байна.

Малын тоо толгой өсөхийн хамт малчин өрхийн тоо нэмэгдэж, өвөлжөө, хаваржааны газрын хүрэлцээ үлэмж мууджээ. Энэ нь бас бэлчээрийн даац хэтрэхэд нөлөөлжээ (Зураг 2-ыг үзнэ үү).

Зураг 2. Малчин өрхийн тооны өөрчлөлт (ҮСХ 2017; 2022, 469; 629)



Зураг 2-оос харахад малчин өрхийн тоо өнгөрсөн 32 жилд 2.6 дахин нэмэгджээ.

Бэлчээрийг хуваарьтай, зохистой ашиглах, бэлчээр хамгаалах ажил хангалтгүй байгаа нь бэлчээрийн даац хэтрэхийн нэг гол шалтгаан мөн. Бэлчээрийн тодорхой хэмжээний газрыг малчдад болон малчдын бүлэгт хариуцуулан хамгаалуулах ажлыг саяхныг болтол олигтой зохион байгуулж ирээгүйн улмаас бэлчээр үндсэндээ эзэнгүйдэж, мал сүргээ өөр аймаг, сум, багийн нутагт оруулан бэлчээх явдал замбараагүй болж, хаа сайгүй бэлчээр доройтож эхэлсэн байна. Өвөлжөөнөөс хаваржаа руу нүүх, бэлчээр сэлгэх, өнжөөх, сэргээх ажил саарч, бэлчээр талхлагдах болжээ.

Бэлчээрийн доройтолд цаг агаарын өөрчлөлт сөргөөр нөлөөлж байна. Цөлжилт тэлж, бэлчээрийн ургамлын тоо цөөрч, олон наст ургамлын оронд шарилж зэрэг ургамал нэмэгдэж байна. Монгол орон газар зүйн байршил, эх газрын эрс тэс уур амьсгал зэргээс хамааран дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтөд эрчимтэй өртөөд байгаа 10 орны нэг бөгөөд дулааны улирлын хур тунадасны хэмжээ ихээхэн буурч хуурайших, гандуу болох, цөлжих явц илүү ажиглагдаж байна. Сүүлийн 80 жилийн уур амьсгалын үндсэн үзүүлэлтийн ажиглалтаар Монгол орны хэмжээнд дундчилсан байдлаар жилийн агаарын температур 2.25 градусаар дулаарч, хур тунадасны хэмжээ 8 хувиар буурчээ. 2020 оны байдлаар нийт нутаг дэвсгэрийн 76.9% буюу 120.3 сая га талбай доройтсон. Үүнээс нэн хүчтэй доройтсон нь 4.7%, хүчтэй доройтсон нь 18.6%-ийг эзлэх ба засаг захиргааны нэгжийн

хувьд Дорноговь, Дундговь, Өмнөговь, Говь-сүмбэр, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Төв аймгийн нийт газар нутгийн 50-70% цөлжилт, газрын доройтолд өртжээ (Цөлжилтийн мэдээллийн сан, БОАЖЯ 2021).

Түүнчлэн ямааны тоо хэт өссөн нь бэлчээр доройтсоны нэг шалтгаан хэмээн зарим судлаач үзэж байна. Ямаа бэлчээрт хониноос илүү халгаатай эсэхийг судлаачид туршиж үзээд ямаа ургамлын үржлийн үе буюу ургалтын үед сорчлон иддэг, сэргэн ургаж байгаа үе буюу хавар хөрсийг малтан ургамлын үндсийг нь сугалан идсэнээс ургамал бүрэн үхэж, хөрс гэмтдэг болохыг тогтоожээ.

Бид мал аж ахуйн өнөөгийн байдал, ялангуяа бэлчээрийн асуудлыг газар дээр нь ажиглаж судлахаар 2023 оны 4 дүгээр сард зүүн гурван аймгийн хэд хэдэн сум, багт ажилласан юм. Бэлчээрийн хүртээмж харьцангуй сайн гэгдэж байсан эдгээр аймагт бэлчээрийн даац хэтэрч, доройтож эхэлсэн байна. Энэ нь дараахь хэдэн шалтгаантай аж. Нэгд, өөр аймаг, сумдын мал, ялангуяа адуу олноор орж ирж, өвөлжиж, хаваржаад буцахгүй үлддэг байна. Улс төрчид, олны танил, нэр нөлөөтэй хүмүүсийн олон мянган адуу Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймагт удаан хугацаагаар байж бэлчээрийн даацыг хэтрүүлэн талхлах нь эрс нэмэгдсэн тухай нутгийн малчид, иргэд хэлж, шүүмжилж байв. Тэдгээр нэр нөлөөтэй хүмүүс өөрсдөө хот суурин газар сууж, харин адуу малаа алс хол гаргаж, малчид, туслах малчдад хөлс төлж хариулуулдаг байна. Тэд малын тоо толгойн татвараа өөрсдийн харьяа газар төлдөг бөгөөд бусад аймаг, сумын бэлчээр ашигласны төлөө ямар ч төлбөр төлдөггүй ажээ.

Хоёрт, малын тоо нэмэгдсэний зэрэгцээ малчид сэлгэн нүүх нь багассан ажээ. Малчид нэг газраас нүүлээ гэхэд тэр газар луу нь өөр малчид шахаад ороод ирдэг учир малчид нүүж суухаа багасгасан байна. Үүний улмаас бэлчээрийг сэлгэн сэргээх явдал бараг зогсчээ. Гуравт, Дорнод, Сүхбаатар аймаг руу адуу малаа оруулахаар явж буй малчид замдаа Хэнтий аймгийн сумдаар дайран өнгөрөхдөө олон хоног явж, бэлчээрийг муутгадаг байна. Отрын замыг тусгайлан тогтоож, зааж өгөөгүй учир оторчид, нүүдлийн хүмүүс дуртай газраараа хэрэн явж малаа адгуулдаг ажээ. Дөрөвт, бэлчээрийн даац хэтэрч, өвсний гарц муудан намсахын хамт оготно олширч, малын хөлд нэрвэгдсэн бэлчээрийг улам муутгадаг байна. Урьд нь хадлан их авдаг сумдад бэлчээр нийтдээ доройтсоны улмаас ойрын 4-5 жил хадлан авах боломжгүй болсон тухай бидэнд ярьсан болно.

Бэлчээрийн даац хэтэрсний улмаас мал цадахгүй, өлөн зэлмүүн явж, улмаар давжаарахад хүрчээ. Бид 2023 оны хавар судалгаагаар явахдаа Дорнод аймгийн Хөдөө аж ахуйн газрын албаны даргатай ярилцахад бэлчээрийн доройтлоос болж эм хонь дунджаар 25-27 кг татдаг байсан бол 22-24 кг болж буурсан, эр хонь 30 кг-аас 27 кг, төлөг 24 кг-аас 21 кг, шүдлэн үхэр 220 кг-аас 180-200 кг, бяруу 120 кг-аас 110 кг болж тус тус буурсан гэж хэлэв. Мал давжаарахын хамт малын амьдын жин буураад зогсохгүй бас ноос, ноолуур зэрэг түүхий эдийн гарц багасах нь тодорхой.

Хоёр. Бэлчээр ашиглалтыг сайжруулах арга зам


Энэ бүхнээс үзэхэд Монголын мал аж ахуйн хамгийн тулгамдсан асуудал бол бэлчээрийн даацын хэтрэлт бөгөөд үүнийг багасгах явдал нэн тэргүүний зорилт болох ёстой. Бэлчээрийн даацыг хэтрүүлэхгүй байх, бэлчээр ашиглалтыг

сайжруулахын тулд цогц арга хэмжээ авах хэрэгтэй гэж үзэж байна. Бүдүүвч 2-ыг үзнэ үү.

Нэгд, малын тоо толгойн өсөлтийг зохистой түвшинд хязгаарлах хэрэгтэй гэж үзэж байна. Үүнийг захиргааны аргаар хийх боломжгүй учир эдийн засгийн аргыг хэрэглэх нь зохистой. Өөрөөр хэлбэл, бэлчээрийн төлбөр тогтоож хэрэгжүүлэх шаардлага тулгарсан. Монгол Улсын Их Хурал 2020 онд “Малын тоо толгойн албан татварын тухай” хууль баталж, “Нэг малын тоо толгойд тухайн татварын жилд ногдуулах албан татварын хэмжээ нь 0-2000 төгрөг байна. Албан татварын хэмжээг энэ хуулийн 6.1-д заасан хязгаарт багтаан сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал малын төрөл тус бүрээр тогтооно. Малчны амьжиргааг дэмжих зорилгоор малчны өмчилж байгаа малын тоо толгойноос хамааран ногдох албан татварын хэмжээг 0 төгрөг байхаар тогтоож болно.” (Монгол Улсын Үндсэн хууль 1992) гэж заажээ.

Энэхүү татварын зорилго нь малын тоо толгойг зохистой хэмжээнд барьж, бэлчээрийн даацыг хэтрүүлэхгүй байлгахад чиглэгдсэн гэж үзэж болох ч хуулийн хэрэгжилтийн байдлаас харахад малын тоог бууруулахад нөлөөлж чадахгүй байна. Энэ нь юуны өмнө татварын хэмжээг бага тогтоосонтой холбоотой.

Бүдүүвч 2. Бэлчээрийг даацыг хэтрүүлэхгүй байх, ашиглалтыг сайжруулах арга зам



Үүний дээр сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал албан татварын хэмжээг багаар тогтоох, малчдыг албан татвараас чөлөөлөх зэргээр хуулийн үйлчлэлийг сулруулж байгаа нь судалгаа хийж явахад ажиглагдав. Тухайлбал, зүүн гурван аймгийн сумдад нэг адуунд 1000-1500, үхэрт 500-800, хонинд 300-500, ямаанд 800-900 төгрөгийн татвар ногдуулж байна. Зарим суманд өрхийн 150 малыг татвараас чөлөөлж, түүнээс давсан малын тоонд татвар ногдуулдаг аж. Бид Малын тоо толгойн албан татварын тухай хуулийг гаргаж байх үед “энэ хэмжээний татвар малын тоог цөөрүүлэхэд нөлөөлж чадах нь эргэлзээтэй. Жишээлбэл, 1000 малтай

малчин хамгийн өндөр хэмжээгээр татвар төллөө гэхэд жилд нийтдээ 2 сая төгрөг болно. Үүнийг ердөө 10 хонь зараад л төлчихнө. 1000 малтай хүнд энэ хэмжээний татвар нэг их үйлчлэхгүй. (Б.Батхишиг 2021, 465) гэж бичиж байсан билээ.

Ер нь энэ татварын нэр нь хүртэл буруу болсон, малчид мал өсгөж үржүүлснийхөө төлөө татвар төлөх нь утгагүй гэж үзэх хүмүүс ч тааралдаж байв. Иймд Малын тоо толгойн албан татварыг Бэлчээрийн төлбөрийн тухай хууль болгон өөрчилж, төлбөрийн хэмжээг нь олон малтай байх биш, харин чанар сайтай цөөн малтай байх сонирхлыг төрүүлэхүйцээр тогтоох нь бэлчээрийн даацыг багасгахад үр нөлөөтэй болно гэж үзэж байна. Зах зээлийн нөхцөлд үнэгүй юм, төлбөргүй юм гэж байх ёсгүй. Учир нь үнэгүй, төлбөргүй юм гэдэг нь агаар лугаа адил хүн бүхэнд, амьтан, ургамал бүхэнд хүрэлцээтэй, хангалттай юм байдаг. Гэтэл эдүгээ малын бэлчээр хүрэлцээгүй болсны дээр сайн бэлчээр ховорджээ. Аливаа юм ховор тусмаа үнэтэй байдаг зах зээлийн хуулийн дагуу бэлчээрийг үнэлж, төлбөртэй болгох нь түүний хүрэлцээг зохицуулах ганц арга юм.

Иймд бэлчээрийн төлбөрийг тогтоохдоо дараахь зарчмыг баримтлах нь зүйтэй гэж үзэж байна. Нэгд, тухайн малчин өрхөд хуваарилсан бэлчээрийн даацыг хэтрүүлсэн тохиолдолд хэтэрсэн мал тутамд өсгөн нэмэгдүүлэх төлбөр ногдуулах, хоёрт, бэлчээрийг өвөл, хавар, зун, намар хэрэглэх гэж ангилан, тухайн улирал дуусмагц дараагийн улирлын бэлчээр лүү нүүгээгүй бол бэлчээрийн төлбөрийг өсгөн нэмэгдүүлж тогтоох, гуравт, бэлчээрийн даацыг хэтрүүлээгүй бол бэлчээрийн төлбөрийг хөнгөлөх, дөрөвт, өөр аймаг, сумаас нүүн ирсэн бэлчээрийн төлбөрийг нутгийн малчдынхаас илүү байхаар тогтоох, хэрэв нэг улирлаас илүү хугацаагаар байвал өсгөн нэмэгдүүлэх төлбөр ногдуулах, тэгэхдээ уг төлбөрийг бэлчээрийг нь ашигласан суманд төлж байх зэрэг болно.

Өөрөөр хэлбэл, бэлчээрийн төлбөр нь малынхаа тоог тухайн бэлчээрийн даацаас хэтрүүлэхгүй байх, бэлчээрийг жилийн дөрвөн улиралд байнга сэлгэдэг байх сонирхлыг малчдад төрүүлэх, өөр аймаг, сумын нутаг бэлчээр лүү нүүх нь илүү их төлбөр, зардалтай байх учир аль болох өөрсдийн бэлчээр нутгийг арчлах, хамгаалах, сэргээх шаардлагатайг мэдрүүлэхэд чиглэгдвэл зохино.

Хоёрт, бэлчээрийн менежментийг сайжруулах, өөрөөр хэлбэл, бэлчээр ашиглалт, хамгаалалт, сэргээлтийг чанартай хийдэг болгох асуудлыг нарийн бодож боловсруулан шийдвэрлэх хэрэгтэй байна. Энэ тухайд академич А.Бакей бичихдээ “...малчид бэлчээрийг дундаа эзэмшиж, олонхын саналд тулгуурлан шийдвэр гаргаж, зүй зохистой ашиглах, хяналт тавих боломж байна. Бэлчээрийн даацад нийцүүлэн малын тоо толгойг хязгаарлах эдийн засгийн уян хатан хөшүүрэг бүхий бэлчээр ашиглалтын тогтвортой менежментийг нэн даруй хэрэгжүүлэх шаардлагатай байна” (А.Бакей 2016, 214) гэжээ.

Сүүлийн үед малчдын бүлэг, нөхөрлөл байгуулж, тодорхой хэмжээний бэлчээрийн газрыг хариуцуулан ажиллуулах, бэлчээрийн менежментийн ажлын хэсэг байгуулах зэрэг санал, санаачлага гаргаж байна. Тэд бэлчээрээ хуваарилж, ээлжилж сэлгэн ашиглах, бэлчээрийн даацыг тооцож, мал сүргийнхээ тоо толгойг зохицуулах, талхлагдсан бэлчээрийг хэсэг өнжөөж сэргээх, өвөлжөө, хаваржааны бэлчээрийг хамгаалах, олон наст ургамал тариалах зэрэг ажил хийж байгаа аж. Мөн орон нутгийн захиргаанаас өвөлжөө, хаваржааг малчдад эзэмшүүлэх, бэлчээр

ашиглах, хариуцлагажуулах журам гаргаж мөрдүүлэх арга хэмжээ авч эхэлжээ. Ер нь бэлчээрийг эзэмшиж, ашиглаж байгаа хүнээс илүү сайн хамгаалж, сайжруулах өөр этгээд байхгүй гэдэг нь тодорхой юм.

Мал аж ахуйн хөгжлийн цаашдын хандлагын талаар доктор Л.Эрхэмбаяр эргэцүүлэхдээ “Бэлчээрийн тухай хуулиасаа эхлэх ёстой. Газар бол бүх юмны эхлэл. Газраа зөв хуваарилан, бэлчээрээ талхлахгүй байлгахаас эхлэх хэрэгтэй. Бэлчээр эзэнтэй болохоор газрыг цөлжүүлэхгүй байх, талхагдалд оруулахгүй байх үүргийг эзэн нь хүлээнэ. Хүнд бэлчээрийг нь заагаад, гаргаад өгчихөөр түүндээ багтсан хамгийн өндөр үр ашигтай мал аж ахуйг эрхлээд эхэлнэ.” (Л.Эрхэмбаяр 2023) гэж хэлсэнтэй санал нийлж байна.

Бэлчээрийг ашиглах талаарх харилцаа бол бэлчээрийг өмчлөх юмуу эзэмших түвшний харилцаа биш. Энэ бол бэлчээрийг хямгатай, хуваарьтай ашиглах, бэлчээрийн даац хэтэрч доройтохоос хамгаалах, бэлчээрийг нөхөн сэргээх талаарх малчдын хоорондын харилцаа юм. Бэлчээрийг ашиглах харилцааны дараагийн түвшин бол бэлчээрийг эзэмшүүлэх харилцаа юм. Гэхдээ бэлчээрийн мал аж ахуйн нөхцөлд бэлчээрийг эзэмшүүлэх харилцааг өргөн хүрээнд хэрэгжүүлэх боломжгүй. Иймд түүнийг хязгаарлагдмал хүрээнд, тухайлбал, зөвхөн өвөлжөө, хаваржааны газрыг нь эзэмшүүлэх хэлбэрээр хэрэгжүүлж болно гэж үзэж байна. Өвөлжөө, хаваржаа бол малын хашаа хороо, саравч зэрэг үл хөдлөх хөрөнгө бүхий газар бөгөөд уг газрыг эзэмшүүлэх нь бас малчдын үл хөдлөх хөрөнгийг хамгаалах нэг арга болно. Гагцхүү малчдад өвөлжөө, хаваржааныхаа орчим бэлчээрийг хямгадан хамгаалах, нөхөн сэргээх, худаг усыг хамгаалах зэрэг үүрэг хүлээлгэх ёстой.

Иймд бэлчээр ашиглалтыг сайжруулах, мал аж ахуйн салбарын үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх хэрэгтэй байна. Академич А.Бакей мал аж ахуйн хөгжлийн бодлого, эрх зүйн орчныг шинэчлэх гол чиглэлийг зурагласныг бүрдүүвч 2-т үзүүлэв.

Бүдүүвч 2. Мал аж ахуйн хөгжлийн бодлого, эрх зүйн орчныг шинэчлэх гол чиглэл

(А.Бакей, Г.Долгорсүрэн 2021, 11)



Бүдүүвч 2-оос харахад юуны өмнө бэлчээр ашиглах, хамгаалах асуудлыг хууль, эрх зүйн үүднээс зохицуулах шаардлагатай бөгөөд ингэхдээ малчдад ашиглах бэлчээрийн хил заагийг тодорхой болгох хэрэгтэй юм. Энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд малчдын хандлага, хариуцлагыг өөрчилж, хүлээх хариуцлагын шалгуурыг тогтоох ёстой. Эцсийн дүнд бэлчээр нутгаа хамгаалах, үржил шимийг нь дээшлүүлэх ажлыг малчид өөрсдөө хариуцах ёстой. Тэднээс өөр бэлчээр нутагт ойр байгаа хүн байхгүй. Тэднээс өөр бэлчээр нутгийг хамгийн ихээр ашиглаж байгаа хүн байхгүй.

Иймд малчдыг тодорхой зохион байгуулалтад оруулж, хамтарч ажиллах, хамтарч бэлчээр орчноо хамгаалах явдалд сургах шаардлагатай. Малчин бүр бэлчээр орчноо хамгаалагч, бас байгаль хамгаалагч байх ёстой гэсэн ухамсар, сэтгэлгээг суулгаж, хэрхэн хамгаалж, нөхөн сэргээх талаарх зөвлөх, сургах үйлчилгээг /экстейншн/ явуулж, мэдлэг, соёлыг дээшлүүлэх нь чухал.

1959-1990 онд хэрэгжсэн нэгдэлжих хөдөлгөөн, хөдөө аж ахуйн нэгдлийн үйл ажиллагаа нь малчдад хамтран хөдөлмөрлөх, харилцан туслах соёлыг тодорхой хэмжээгээр суулгасан. Гэвч өнгөрсөн 30 гаруй жилд нэгдлийн малчдын үе бараг дуусаж, хувийн өмчтөн малчдын шинэ үе бий болсон бөгөөд энэ шинэ үеийнхэнд хамтран ажиллах арга, ач холбогдлыг сурталчлан таниулах, зааж сургах ажил ихээхэн хэрэгтэй байна.

Мал аж ахуйн хөгжлийг дүгнэхэд тогтвортой байдлын үнэлгээ нэн чухал болсныг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Малчин өрхийн хувьд энэ нь бэлчээрийн хүрэлцээ, чанар, малын ашиг шимийн үзүүлэлт, малын эрүүл мэнд, үржил угсааны байдал, мал маллах хүн хүч, дадлага туршлага, эрсдэлийг давах бэлтгэл зэрэг экологи, эдийн засаг, нийгмийн хүчин зүйлсийг хамрах учиртай. Олон тооны малтай байлаа ч гэсэн тогтвортой байдлын нөхцөлийг хангаагүй бол уг малчин өрхийн аж ахуй цаашид хэрхэх нь эргэлзээтэй. Иймд малчдын хөдөлмөрийг үнэлэхдээ тогтвортой хөгжлийн нөхцөлийг хангаж буй эсэхийг харгалзах зайлшгүй шаардлагатай юм.

Бэлчээр ашиглах, хамгаалах талаар хамтран ажиллах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, мал аж ахуйн тогтвортой хөгжлийн нөхцөлийг хангах дадал, чадварыг малчдад эзэмшүүлэх талаар төр засгийн тусламж, дэмжлэг, зөвлөх үйлчилгээ, урамшуулал нэн чухал юм. Ялангуяа малчдад удирдлага, зохион байгуулалтын зөвлөгөө, санхүү, урамшууллын дэмжлэг, техник, технологийн туслалцаа, нийгэм, соёлын үйлчилгээ үзүүлэхэд төр засгийн холбогдох байгууллагууд тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулж байх нь зүйтэй.

Гуравт, бэлчээрийн даацыг хэтрүүлэхгүй байх, бэлчээрийн ашиглалтыг сайжруулахын тулд малыг олон жилийн турш бэлчээж өсгөх биш, харин өсвөр насанд нь эрчимжсэн мал аж ахуйн фермүүдэд өгч, малынхаа тоог зохистой хэмжээнд барьж байх нөхцөлийг бүрдүүлэх нь чухал юм. Бид зүүн гурван аймгаар судалгаа хийж явахдаа өсвөр мал худалдан авч, богино хугацаанд бордон жинг нь нэмэгдүүлдэг Мета агро хэмээх компанийн аж ахуйтай танилцсан юм. Саяхан байгуулагдсан тус аж ахуй жилд 5000 өсвөр үхэр /18-20 сартай/ худалдан авч 90 хоног бордон тэжээдэг байна. Энэ хугацаанд үхрийн жин бараг 90 кг-аар нэмэгддэг байна. Буудай, арвай зэрэг үр тариагаар дарш, фермекс хийж тэжээх бөгөөд ингэхэд

үхэр махан тарга сайн авч, жин нь хурдан нэмэгддэг ажээ. Өсвөр малыг байнга хашаанд байлган тэжээх бөгөөд 1 хашаанд ойролцоо насны 60 үхэр байдаг аж. Тус аж ахуйд мал хүлээн авч ангилах байр, анхан шатны үзлэг хийх байр, мал эмнэлгийн байр, усны байр гэх зэрэг байгууламжууд бий. Тус компани фермийнхээ ойролцоо газар авч үр тариа тариалахаар төлөвлөсөн бөгөөд ингэснээр малын тэжээлийг өөрсдөө бэлтгэх боломжтой болох гэнэ.

Цаашид ийм эрчимжсэн аж ахуйн тоо нэмэгдэх төлөвтэй байна. Зөвхөн өсвөр насны үхэр төдийгүй бас намрын хурга болон төлөг авч бордох аж ахуй байгуулагдах гэж байгаа ажээ. Эрчимжсэн мал аж ахуйн бүтээгдэхүүнийг дотоодоос гадна гадаадад гарган борлуулах боломжтой юм.

Дөрөвт, малын тоог бэлчээрийн даацтай нийцүүлэх гол арга бол нэгд, махны дотоодын хэрэгцээг бүрэн хангах, хоёрт, махны экспортыг нэмэгдүүлэх явдал юм. Махны дотоод, гадаадын хэрэгцээг хангахын тулд дараахь шаардлагыг биелүүлэх хэрэгтэй. Бүдүүвч 3-ыг үзнэ үү.

Бүдүүвч 3. Бэлчээрийн даацад нийцүүлэн мах бэлтгэлийг нэмэгдүүлэх нь



Мах бэлтгэлийн мөрдөн мөшгөх систем нь малыг бүртгэж, гарал үүслийг нь аймаг, сум, баг, малчны юмуу фермерийн хаяг, мал эмнэлгийн үйлчилгээнд хамрагдсан эсэхээр зааж ээмэгжүүлнэ. Түүнчлэн тухайн малд хэзээ ямар вакцин, эм тариа хэрэглэсэн тухай мэдээлэл хүртэл мөшгөх бар кодоод тэмдэглэгдэнэ. Мал нядлах үйлдвэр, цех, мах боловсруулах үйлдвэр мөшгөх бар кодтой махыг боловсруулж, худалдааны газруудад өгөхдөө уг кодыг бас дамжуулна. Ингэснээр гарал үүсэл нь тодорхой мах, махан бүтээгдэхүүн дотоод, гадаадын хэрэглэгчдэд очно. Ялангуяа экспортын зах зээл дээр тухайн бүтээгдэхүүний чанар, гарал үүсэл тодорхой байх учир хялбар борлогдоно.

Махны стандартыг хангах нь түүний экспортын хэмжээ болон үнэ цэнийг нэмэгдүүлэх гол нөхцөл юм. Энэ тухайд мал аж ахуйн мэргэжилтэн бичихдээ “Нэг төрлийн ижил чанартай, ижил стандарттай махан бүтээгдэхүүн гаргаад ирэхээр үнэ цэнэ нь нэмэгддэг. Бидний гаргаж буй хонины мах нэг бол тарган, эсвэл туранхай, нэг бол зөөлөн шүүслэг эсвэл хатуу, нэг бол дандаа өөх эсвэл дан хар мах гэх мэтээр ямар ч стандартгүй. Стандартад нийцүүлж жигдлээгүй ийм бүтээгдэхүүн үнэд хүрдэггүй. Нэгэн жигд үнэ цэнэтэй мах болгохын тулд малчид заасан стандартын дагуу хургаа өсгөж, махлуулаад дараагийн мал бордох аж ахуй руу нийлүүлдэг. Мал бордох аж ахуй нь дахин дээд түвшинд хүргээд борлуулбал үнэд хүрнэ.” (Л.Эрхэмбаяр 2023) гэжээ.

Үнэхээр бэлчээрийн гарц, чанар янз бүр байгаагаас махны стандартыг хангахад бэрхшээл учирч байна. Иймд өсвөр насны мал бордож жинг нь нэмэгдүүлдэг аж ахуйнуудыг дэмжиж олшруулах нь чухал юм. Ингэснээр бэлчээрийн даацын хэтрэлт багасах төдийгүй махны нөөц нэмэгдэж, дотоод, гадаадын хэрэглээ өснө. Энэ нь бэлчээрийн мал аж ахуй ба эрчимжсэн мал аж ахуй, мал аж ахуй ба газар тариалангийн хамтын ажиллагаа, харилцан хамаарал, харилцан дэмжлэгийг хүчтэй болгох гол арга зам болох нь тодорхой.

Тавд, мал, мах бэлтгэлийн тогтолцоог зах зээлийн нөхцөлд нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна. Эдүгээ мах бэлтгэл, махны өртөг бүрэлдэх сүлжээ нь дараахь үндсэн хэсгүүдээс бүрдэж байна. Бүдүүвч 4-ийг үзнэ үү.

Бүдүүвч 4. Махны өртөг бүрэлдэх сүлжээ (Б.Батхишиг 2021, 466)



Махны өртөг бүрэлдэх сүлжээний хэсэг тус бүрт хүндрэл, бэрхшээл байгаа бөгөөд тэдгээрийг харилцан уялдаатай шийдвэрлэхгүйгээр нийт системийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж чадахгүй юм. Гэтэл мах бэлтгэлийн тогтолцоо тодорхой зохион байгуулалт, төрийн зохицуулалтгүй урсгалаараа явагдаж байна. Уг тогтолцоог үндсэндээ махны ченжүүд хэмээх хувийн наймаачид, зуучлагчид хянаж эрхэлж байна.

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчдийн төлөө газрын судалгаагаар малын мах хэрэглэгчийн гар дээр ирэх хүртлээ 6-7 шат дамжлага дамждаг болохыг тогтоожээ. Үүний уршгаар махны үнэ малчнаас хэрэглэгчид хүрэх явцад бараг хоёр дахин нэмэгддэг байна. Ченжийн ийм тогтолцоотой нөхцөлд махны чанар, эрүүл ахуйн шаардлагад хяналт тавих нөхцөл, боломж бага юм.

Мал, мах бэлтгэлийн системийг орчин үеийн зах зээлийн нөхцөлд нийцүүлэх үндсэн арга зам бол биржийн худалдаа юм. Эдүгээ тус улсын бүх аймаг, сум интернетийн сүлжээнд холбогдсон учир цахим биржийн тогтолцоог бүрдүүлэх боломжтой болсон. Цахим бирж нь нэг талаас мал, мах нийлүүлэгч малчин болон хоршоо, нөхөрлөл, нөгөө талаас мал, мах худалдан авагч үйлдвэр, цехүүдийг хооронд нь шууд холбож өгөх бөгөөд ингэснээр малчид зах зээлийн тухайн үеийн үнээр мал, махаа борлуулах боломжтой болно.

Цахим биржээр борлуулсан барааг худалдагчаас хэрэглэгчид найдвартай, түргэн шуурхай хүргэж өгдөг тээвэр, үйлчилгээний мэргэжсэн компаниуд үүсэж хөгжих нь дамжиггүй. Худалдагч, хэрэглэгч хоёр хоорондоо тохиролцон бараа, бүтээгдэхүүнийг өгч, авалцах, хадгалж тээвэрлэх арга хэрэгслээ сонгож бас болно.

Дүгнэлт

Сүүлийн жилүүдэд малын тоо толгой үлэмж өссөн, бэлчээрийг хуваарьтай, зохистой ашиглах, бэлчээр хамгаалах ажил хангалтгүй байгаа, цаг агаарын өөрчлөлт зэрэг шалтгааны улмаас мал аж ахуйн үйлдвэрлэлийн үндсэн нөхцөл болох бэлчээрийн даац хэтэрч, доройтолд орж байна. Энэ нь мал аж ахуйн цаашдын хөгжилд сөргөөр нөлөөлөх уршигтай тул бэлчээрийн даацын хэтрэлтийг багасгах, бэлчээр ашиглалтыг сайжруулах нь тус салбарын хамгийн гол асуудал болж байна.

Бэлчээр ашиглалтыг сайжруулахын тулд малын тоо толгойг бэлчээрийн даацад нийцүүлэх, үүний тулд эдийн засгийн болон бусад арга хэмжээ авах, бэлчээрийн менежментийг сайжруулахад малчдын оролцоог нэмэгдүүлэх, өсвөр насны малыг бордох, махны дотоодын хэрэгцээг бүрэн хангах, экспортыг нэмэгдүүлэх, мал, мах бэлтгэлийн системийг шинэчлэх зэрэг олон талт арга хэмжээг иж бүрэн авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Ашигласан материал

ҮХС. 2017; 2022. *Монгол Улсын статистикийн эмхэтгэл*. Уб: Үндэсний статистикийн хороо, 459; 629 дахь талууд

ҮСХ. 2017; 2022. *Монгол Улсын статистикийн эмхэтгэл*. Уб: Үндэсний статистикийн хороо, 414; 498 дахь талууд

Монгол Улсын Үндсэн хууль. 1992. “6 дугаар зүйлийн 1.”

www.dnn.mn. 2022. *Нийт нутгийн 60 гаруй хувьд бэлчээрийн даац хэтэрсэн байна*. . 08 29. www.dnn.mn.

Б.Пүрэв, А.Бакей. 2020. *Хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийн шинжлэх ухааны үндэслэл*. Уб.

ҮСХ. 2022. *Монгол Улсын статистикийн эмхэтгэл*. Уб.

Цөлжилтийн мэдээллийн сан, БОАЖЯ. 2021. www.eic.mn.

Монгол Улсын Үндсэн хууль . 1992. *Малын тоо толгойн албан татварын тухай Монгол Улсын хууль*, 6.1., 6.2., 6.3.

Батхишиг Б. 2021. *Адам Смитийн онол ба эдийн засгийн философи*. Уб.

Бакей А. 2016. *Монголын бэлчээрийн мал аж ахуйн тогтвортой хөгжил, Онол-арга зүйн асуудлууд.*

Л.Эрхэмбаяр. 2023. “Цөлжилтөөс сэргийлэх хамгийн эхний ажил нь бэлчээрийг хуваарилах юм.” *Өдрийн сонин.* 04 20.

Бакей А., Долгорсүрэн Г. 2021. *Уур амьсгалын өөрчлөлтөд мал аж ахуйн салбарын дасан зохицох чадавхыг бэхжүүлэх бодлого, хууль эрх зүйн шинэчлэлийн асуудал.* УБ.